



УВС АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 4/82

Улаангом

Журамд нэмэлт өөрчлөлт
оруулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.17, Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Хөндөгдсөн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгж, нөхөрлөлийг сонгон шалгаруулж, үйл ажиллагаанд нь хяналт тавих журмын 3.2 хэсэгт заасан ...дахин угаах замаар ... гэснийг хүчингүйд тооцож ... Гурав¹ нөхөн сэргээлт хийх ажлын санхүүжилт... гэсэн бүлгийг нэмж өөрчилсүгэй.

ДАРГА  Ч.ЧИМЭД



ХӨНДӨГДСӨН ГАЗАРТ НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙХ АЖ АХУЙН НЭГЖ, НӨХӨРЛӨЛИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД НЬ ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Сүүлийн жилүүдэд гар аргаар алт олборлогчид туршлагажиж, ашиглаж буй технологи сайжирснаар газрыг их хэмжээгээр эвдэн сүйтгэж, байгалийн унаган төрхийг алдагдуулж байна. 2013 онд хөндөгдсөн газрын тооллогоор гар аргаар ашигт малтмал олборлолт болон зам барилга байгууламжийн элс хайрга олборлолт, тоосгоны үйлдвэрлэл, уул уурхайн нөлөөллөөс 10 сумын нутгийн 526,19 га газар хөндөгдсөн байна.

Иймд аймгийн газар нутагт байгаа хууль бусаар хөндөгдсөн талбайд нөхөн сэргээлт хийх шаардлага зүй ёсоор гарч байна.

Хоёр. Журмын зорилго

2.1 Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанаас эвдэгдэн орхигдсон болон хувиараа ашигт малтмал олборлогчдын хууль бусаар хөндсөн талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллага, иргэдийн нөхөрлөлийг сонгон шалгаруулах, нөхөн сэргээлт хийх үйл ажиллагаанд нь хяналт тавих, нөхөн сэргээсэн талбайг актаар хүлээн авахад энэхүү журмын зорилго оршино.

Гурав. Нөхөн сэргээлт хийх шаардлагатай газар

3.1 Хариуцах эзэн холбогдогч нь тодорхойгүй болсон талбайг нөхөн сэргээнэ.

3.2 Сонгон шалгаруулалтад орж гэрээ байгуулан ажиллаж байгаа аж ахуйн нэгж, нөхөрлөл нь тухайн газар дээрх хаягдал, шлам, отволи, овоолгыг дахин угаах замаар нөхөн сэргээлтийн ажлаа санхүүжүүлнэ.

/ Энэ хэсгийг 2015 оны 06-р сарын 11-ний өдрийн хурлаар хүчингүй болгосон./

3.3 Тухайн жилийн нөхөн сэргээлт хийх талбайн тоо, хэмжээ, цэг солбилцолыг аймгийн Засаг даргын захирамжаар томилсон ажлын хэсэг тогтоож, тэдгээрийн саналыг үндэслэн аймаг, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулна. Тухайн жилд нөхөн сэргээхээр батлагдсан нийт газрын 70 хувьд аж ахуйн нэгж, 30-аас доошгүй хувьд нь нөхөрлөл нөхөн сэргээлт хийнэ. Нөхөн сэргээх газрын хэмжээ, байршлыг тухайн сум тогтооно.

Гурав¹. Нөхөн сэргээлт хийх ажлын санхүүжилт

3¹.1 Нөхөн сэргээлт хийх ажлын санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

3¹.1.1. Улсын төсөв

3¹.1.2. Орон нутгийн төсөв

3¹.1.3. Олон улсын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт

Дөрөв. Нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжид тавих шаардлага

4.1 Нөхөн сэргээлт хийх хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй байна.

4.2 Мэргэжлийн геологи, экологийн мэргэжилтэнтэй байна. Экологийн мэргэжилтэн нь тухайн компаний үндсэн ажилтан байна.

4.3 Нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг явуулах шаардлагатай ажиллах хүч, техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

4.4 Татвар, нийгмийн даатгал, банкны хугацаа хэтэрсэн өргүй байна.

4.5 Нөхөн сэргээлт хийх нөхөрлөл нь албан ёсны нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан, оноосон нэртэй байна.

Тав. Сонгон шалгаруулалтын комисс томилох

5.1 Хөндөгдсөн газрын нөхөн сэргээлтийн захиалагч нь аймгийн ЗДТГ-ын ХБХ, БОГ байна.

5.2 Аж ахуйн нэгж, нөхөрлөлийг сонгон шалгаруулах комиссыг 7-с доошгүй гишүүнтэйгээр тухай бүр нь аймгийн Засаг даргын захирамжаар томилно.

Зургаа. Зар мэдээ

6.1 Сонгон шалгаруулалтын зар мэдээг БОГазар 7-с доошгүй хоногийн дотор орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлана.

6.2 Зар мэдээнд хөндөгдсөн газрын талбайн хэмжээ, уул-техникийн нөхцөл, тодорхойлолт сонгон шалгаруулалтанд оролцох аж ахуйн нэгж, нөхөрлөлд тавигдах ерөнхий болон тусгай шаардлага бусад холбогдох мэдээллийг оруулна.

6.3 Зар мэдээнд мэдээллийн лавлах утас, хаягийг тодорхой тусгана.

Долоо. Сонгон шалгаруулалтад оролцогчийн бүрдүүлэх материал

7.1 Сонгон шалгаруулалтанд оролцохыг хүссэн албан ёсны хүсэлт

7.2 Аж ахуйн нэгжийн танилцуулга /бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, уул уурхайн нөхөн сэргээлт хийх ажлын туршлага, ажиллах хүчний бүтэц, бүрэлдэхүүн, байгууллагын хаяг, утасны дугаар зэргийг дэлгэрэнгүй тусгана/, нөхөрлөл байгуулсан шийдвэр, холбогдох бичиг баримт.

7.3 Аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар

7.4 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг төслөөр ирүүлнэ/. Төлөвлөгөөнд дараах зүйлүүд тусгагдсан байна. Үүнд:

- Нөхөн сэргээлтийн ажлыг эхлэх, дуусгах үе шатны календарчилсан төлөвлөгөө

- Нөхөн сэргээлтэнд ашиглах техник хэрэгслийн жагсаалт /техникийн улсын бүртгэлийн гэрчилгээ, түрээсийн гэрээ/

- Ажиллах хүчний мэдээлэл

- Техникийн болон биологийн нөхөн сэргээлтэд шаардагдах зардлын хэмжээг тооцож гаргасан байна.

7.5 Сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан бусад шаардлагыг хангасан байна.

Найм. Төсөл ирүүлэх, шалгаруулах

8.1 Оролцогч тодорхой нэгж 2-оос илүүгүй талбайг сонгож, талбай бүр дээр хийх ажлынхаа төсөл төлөвлөгөөг ирүүлнэ.

8.2 Сонгон шалгаруулалт нь төсөл хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 14 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

8.3 Захиалагч төсөл хүлээн авах эцсийн хугацаанаас хоцорч ирүүлсэн аливаа төслийг "хугацаа хоцорсон" гэж үзэж буцаана.

8.4 Төслийг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжтэй холбогдсон мэдээллийг тухайн төсөл шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй хүнд задруулахыг хориглоно.

8.5 Захиалагч нь сонгон шалгаруулалтын бичиг баримтын шаардлагад үл нийцсэн гэж тогтоогдсон төслөөс татгалзаж оролцогчид ажлын 7 хоногт багтаан албан бичгээр мэдэгдэнэ.

8.6 Захиалагч "шаардлагад нийцсэн" төсөл ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.

8.7 Захиалагч нь талуудын хооронд тохирсон бүх нөхцлүүдийг тусгасан гэрээний маягыг гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан оролцогчид илгээнэ.

Ес. Гэрээ байгуулах

9.1 Шалгарсан аж ахуйн нэгж, нөхөрлөл ажлын 10 хоногт багтаан, аймгийн Засаг даргатай гэрээ байгуулна.

9.2 Гэрээний бусад оролцогч талууд нь аймгийн БОГ, тухайн сумын Засаг дарга байна.

9.3 Гэрээнд, шалгарсан аж ахуйн нэгж, нөхөрлөл болон сум орон нутгийн эрх үүргийг зааж өгнө.

9.4 Нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгж 5.0 сая төгрөгийн, бичил уурхай эрхлэгч нөхөрлөл нь 2.0 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг гэрээнд заасан тусгай дансанд урьдчилж байршуулах бөгөөд гэрээний үүргээ биелүүлээгүй бол үл маргах журмаар барьцаа төлбөрөөр гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулна.

9.5 Нөхөн сэргээлт хийх эрх авсан аж ахуйн нэгж, нөхөрлөл нь бусдад эрхээ шилжүүлэхийг хориглоно.

9.6 Гэрээг тухайн жилийн р сарынны дотор дүгнэж, гэрээний үүргээ хангалттай биелүүлсэн тохиолдолд барьцаа хөрөнгийг гүйцэтгэгчид буцаан олгоно.

9.7 Нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, байршил, хийх хугацааг гэрээнд тодорхой тусгаж өгнө.

Арав. Хяналт шалгалт

10.1 Гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих ажлын хэсгийг аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчны газар, Цагдаагийн газар, тухайн сумын Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчийг оролцуулан, аймгийн Засаг даргын захирамжаар байгуулна.

10.2 Энэ журмын 10.1-д заасан ажлын хэсэг нь хамтарсан хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдалд шуурхай арга хэмжээ авч ажиллана.

10.3 Нөхөн сэргээлт хийх газрын хил заагийг Хөгжлийн бодлогын хэлтэс, Байгаль орчны газар, сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, газрын даамал, байгаль хамгаалагч нар GPS багажаар хэмжиж хилийн шав тэмдэг тавьж өгсөнөөр тухайн аж ахуйн нэгж, нөхөрлөлийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулах эрх нээгдэнэ.

10.4 Гүйцэтгэгч 10.3-т заасан талбайн гадна талд хөрс хуулсан тохиолдолд захиалагч гэрээг цуцлах бөгөөд байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.

10.5 10.4-т заасан нөхцөл байдал илэрсэн тохиолдолд барьцаа мөнгийг буцаан олгохгүй.

Арван нэг. Нөхөн сэргээсэн газрыг хүлээн авах

11.1 Нөхөн сэргээсэн талбайг хүлээн авахдаа “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5917:2008”, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага 5918:2008” стандартуудын дагуу аймгийн комисс хүлээн авч дүгнэлт гаргана.

11.2 Нөхөн сэргээлтийг дууссаны дараа ААН, нөхөрлөл нь тухайн үйл ажиллагааны тайлан бичиж аймгийн ЗДТГ, Байгаль орчны газарт ирүүлнэ.

Арван хоёр. Бусад зүйл

12.1 Энэхүү журам нь батлагдсан өдрөөсөө хүчин төгөлдөр үйлчилнэ.

-----oOo-----